

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201... оны ... дугаар  
сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

### ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тамхины хяналтын тухай хуульд доор дурдсан хэсэг, заалтыг нэмсүгэй:

**1/ 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг:**

“2.3 Тамхины хяналтын тухай суурь конвенц, Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах протокол, Тамхины хяналтын суурь конвенцийг хэрэглэх удирдамжийг төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил сахин биелүүлнэ.”

**2/ 4 дүгээр зүйлийн 4.1.10-4.1.14 дахь заалт:**

“4.1.10. Тамхины хяналтын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн дагуу Тамхины хяналтын суурь конвенцийн үзэл баримтлал, мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөө, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах, эрүүл мэндээ хамгаалуулахтай холбогдсон зарчмыг эн тэргүүнд удирдлага болгож, эдгээрт нийцээгүй аливаа бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг төрөөс батлахгүй байх.”

4.1.11. Тамхи татах цэг байгуулахад улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг хориглох, төрийн байгууллагаас тамхины цэг байгуулахыг хориглох.”

4.1.12. Халдварт бус өвчин, тамхины сөрөг үр дагавар, тамхины утааны сөрөг нөлөөлөл, тамхинаас татгалзсаны эерэг үр дагавар гэх зэрэг агуулгаар, шинжлэх ухааны үндэслэлтэй нийтэд чиглэсэн таниулга, ухуулгыг төрөөс тогтмол дэмжин санхүүжүүлэх.”

4.1.13. Тамхидалтаас татгалзах, тамхины хамаарлаас эмчлэх арга хэмжээ, үйлчилгээг төрөөс дэмжин санхүүжүүлэх, тамхины хамаарлаас гаргах эмийг татваргүйгээр дотооддоо үйлдвэрлэх, импортлох бодлогыг баримтлах.”

4.1.14. Тамхийг онцгой албан татвараас аливаа нөхцөл, журмаас чөлөөлөхөөс татгалзаж, чөлөөт бүсэд, татваргүй барааны дэлгүүрт, бусад газарт тамхинд онцгой албан татвар заавал ногдуулах.”

**3/ 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт:**

“5.1.8. Байгууллагын хүрээнд Тамхины хяналтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж хяналт тавих тодорхой ажилтныг чиг үүрэгт нь нэмэлт оруулах байдлаар томилон ажиллуулан, байгууллагын дотоод журамд болон ёс зүйн дүрэмд тусган хэрэгжүүлэх.”

**4/ 6 дугаар зүйлийн 6.4.3 дахь заалт:**

“6.4.3. навчин болон навчит тамхи эрүүл мэндийн бичвэр анхааруулгатай байна.”

**5/ 6 дугаар зүйлийн 6.10 – 6.12 дахь хэсэг:**

“6.10. тамхийг биет байдлаар ил харагдахааргүй байдлаар, гадна талд нь зөвхөн “Тамхи” гэсэн бичвэрийг цагаан дээр хараар бичиж тусгайлан зориулагдсан, зохих хаалттай тавиуранд худалдана.

6.11. Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхины ургамал тариалах, газар тариалан эрхлэхийг хориглоно.

6.12. Тамхийг Алтанбулаг, Сүхбаатар, Замын-Үүд, Буян-Ухаа хилийн боомт, Улаанбаатар хотын гаалийн хяналтын бүсээс бусад хилийн боомт, гаалийн хяналтын бүсээр импортлож, экспортлохыг хориглоно.

**6/ 7 дугаар зүйлийн 7.5-7.8 дахь хэсэг:**

“7.5. Тамхины хяналтын тухай конвенц, түүний протокол, конвенцийг даган мөрдөх удирдамжийн нөхцөлийг хангаагүй бол тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзах, түдгэлзүүлэх, сунгахгүй байх, цуцлах үндэслэл болно.

7.6. Тамхины үйлдвэрлэлийн, импортын, экспортын тусгай зөвшөөрлийг Тамхины эсрэг үндэсний хорооны дэмжсэн саналгүйгээр олгох, сунгахыг хориглоно.

7.7. Тамхи худалдах Тамхины эсрэг тухайн орон нутгийн хорооны дэмжсэн саналгүйгээр олгох, сунгахыг хориглоно.”

7.8. Тамхи үйлдвэрлэх, худалдах, импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах талаар дүгнэлтийг Тамхины эсрэг үндэсний болон орон нутгийн хяналтын хороо тус тусын эрх хэмжээний хүрээнд гаргана.”

**7/ 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг:**

“8.5. Тамхийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үзүүлэх бүрт “Тамхи таны эрүүл мэндэд хортой.” гэсэн бичвэрийг дэлгэцийн доогуур тухайн байгууллага өөрсдийн зардлаар мэдээлнэ.”

**8/ 10 дугаар зүйлийн 10.5.6-10.5.7 дахь заалт:**

“10.5.6. Тамхины хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар олон нийтийн болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ухуулга, таниулга, Тамхины эсрэг хяналтын хорооны үйл ажиллагаа.

10.5.7. Сангийн зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад чиглэл.”

**9/ 11 дүгээр зүйлийн 11.4-11.10 дахь хэсэг:**

“11.4. Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэд Тамхины эсрэг үндэсний зөвлөлийг төрийн байгууллага, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийн байгууллага, эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулна. ”

11.5. Тамхины хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангах үүднээс Тамхидалтын эсрэг Үндэсний хэмжээний хяналтын хороог төрийн байгууллага, иргэн, иргэний нийгмийн буюу төрийн бус байгууллага, Худалдаа аж үйлдвэрийн танхим, хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага, холбогдох бусад төлөөллийг оролцуулан Ерөнхий сайдын дэргэд ажиллуулна.

11.6. Тамхины хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд хангах үүднээс Тамхины эсрэг орон нутгийн хяналтын хороог аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны түвшинд тухайн шатны Засаг даргын дэргэд энэхүү хуулийн 11.5 дахь хэсэгт заасан олон нийтийн төлөөллөөр ажиллуулна.

11.7. Тамхины хууль тогтоомжийн хэрэгжилтэд хорооны засаг даргын ажлын алба, олон нийтийн байцаагч нар хяналт тавина.

11.8. Хориглосон газарт тамхи худалдахгүй байх, тамхи татахгүй байх, тамхи, түүний хайрцаг, сануулах хуудсыг хогийн савнаас гадуур хаяхгүй байх талаар аливаа иргэн шаардлага тавих эрхтэй. Тэрхүү шаардлагыг тамхи худалдаж буй, тамхитай холбогдох этгээд биелүүлэх үүрэгтэй. Иргэний шаардлагыг тамхитай холбоотой этгээд биелүүлэхгүй байвал тухайн иргэн цагдаагийн албан хаагч, хорооны засаг даргын ажлын албанд мэдээлнэ.

11.9. Дотоод орчин болон гудамж талбайн хориглосон газарт тамхи хэрэглэж буй нь дүрст бичлэгээр илэрсэн бол хуульд заасан хариуцлагыг

буруутай этгээдэд ногдуулах талаар тухайн байгууллагын захиргаа болон засаг даргын ажлын алба зохих арга хэмжээг заавал хэрэгжүүлнэ.

11.10. Тамхины хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлэх зорилгоор мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олон нийтийн мэдээллийн болон үүрэн утасны цахим сүлжээ, программыг ажиллуулах бөгөөд зохих мэдээллийн дагуу энэ хуульд заасан хариуцлагыг улсын байцаагч буруутай этгээдэд хүлээлгэнэ.”

**2 дугаар зүйл.** Тамхины хяналтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Тамхины хяналтын тухай хууль тогтоомж нь” гэсний дараа “Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль” гэж, Тамхины хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “хана,” гэсний дараа “тусгаарлагч” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “бүрэн эрхийнхээ дагуу” гэсний дараа “Тамхины хяналтын суурь конвенцийг хэрэгжүүлэх,” гэж, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “тухай” гэсний дараа “зурагт болон бичвэр” гэж, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтын “зурагт” гэсний дараа “болон бичвэр” гэж, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “Анхааруулгын” гэсний өмнө “Зурагт болон бичвэр” гэж, 6 дугаар зүйлийн 6.7.1 дэх заалтын “заагаагүй” гэсний дараа “, хадгалалтын хугацаа дууссан” гэж, 6 дугаар зүйлийн 6.7.8 дахь заалтын “худалдах” гэсний дараа “, мал, амьтан, бараа, бүтээгдэхүүнээр солих” гэж, 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтын “хичээлийн болон дотуур байраас” гэсний дараа “цэцэрлэг, ясли, хүүхдийн сувиллаас ” гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг” гэсний дараа “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “мэдээллийн хэрэгсэл” гэсний дараа “нийгмийн сүлжээ, клип, шторк, ” гэж, тус заалтын “зар” гэсний дараа “сурталчилгаа, ” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “газар” гэсний дараа “, нийтийн эзэмшлийн зогсоол” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалтын “эмнэлэг, сувилал, тэдгээрийн” гэсний дараа “50 метрээс доошгүй” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “6.7.15,” гэсний дараа “6.8, ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалтын “энэ хуулийн” гэсний дараа “5.1.8, 5.2.5, ” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Тамхины хяналтын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2 дахь заалт:**

“3.1.1. “Тамхин бүтээгдэхүүн/цаашид “тамхи” гэх/” гэж татах, үнэрлэх, зайлах зорилгоор тамхины навчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн, эсвэл нийлэг аргаар гаргаж авсан никотин агуулсан хэрэглээний бүх төрлийн утаат болон утаагүй бүтээгдэхүүнийг, тэр дундаа түүхий тамхи, тамхины хаягдал, тамхи эсвэл тамхи орлуулагч агуулсан сигар, үзүүрийг нь тайрсан сигар болон нарийн ороосон сигар, янжуур, боловсруулсан бусад тамхи болон тамхи орлуулагч, “нэгэн төрлийн болгосон” буюу “сэлбэгдсэн” тамхи; тамхины ханд болон охь, задгай тамхи (тамхи орлуулагчийг ямар нэг хэмжээгээр агуулсан эсвэл агуулаагүй), усан

хоолойгоор татах зориулалттай тамхи, гаансаар татах зориулалттай дүнсэн тамхи, янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхи болон бусад төрлийн тамхийг:

“3.1.2. “тамхины сав, баглаа боодол” гэж бөөний болон жижиглэнгийн худалдаанд ашиглагддаг, түүнчлэн тамхин бүтээгдэхүүний анхдагч, хоёрдогч болон дараачийн шатны аливаа сав, баглаа боодол, тамхины хайрцаг, сануулгын дагалдах хуудсыг,”

**2/ 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:**

“3.1.11. “тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдаа” гэж тамхин бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, тээвэрлэх, хүлээн авах, эзэмших, түгээх, худалдаалахад хуулиар хориглосон аливаа үйлдэл хийх, эдгээр үйлдлийг дэмжих зорилго бүхий аливаа үйл ажиллагааг.”

**3/ 5 дугаар зүйлийн 5.1.6 - 5.1.7 дахь заалт:**

“5.1.6. Тамхины хяналтын суурь конвенцийн үзэл баримтлалын дагуу тамхин бүтээгдэхүүний аливаа хууль бус худалдааг илрүүлэх, таслан зогсоох, хяналт тавих системийг нэвтрүүлэх.

5.1.7. энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан хориглосон газраас бусад гадаад орчин дахь нийтийн эдэлбэр газарт байгуулах утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийн байршлыг аж ахуйн нэгжийн хүсэлтийг харгалзан, төрийн бус байгууллага, иргэдийн нийтийн хурлын саналыг үндэслэн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлах.”

**4/ 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалт:**

“5.2.5. Хуулийн этгээдийн хүрээнд Тамхины хяналтын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж хяналт тавих тодорхой ажилтныг чиг үүрэгт нь нэмэлт оруулах байдлаар томилон ажиллуулан, байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэх.”

**5/ 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:**

“7.1. Тамхи үйлдвэрлэх, тамхи импортлох, экспортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн болон үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналуудыг үндэслэн Засгийн газар олгоно. Тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно. Сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.”

**4 дүгээр зүйл.** Тамхины хяналтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “олгохгүй байх” гэснийг “олгохыг хориглох” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “ажиллахаас татгалзах” гэснийг “ажиллах, татаас хөнгөлөлт үзүүлэхийг хориглох,” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтын “тэмдэг байрлуулах” гэснийг

“тэмдгийг тухайн байгууллагын орох хаалганаас 15 метрийн зайд байрлуулж, гарах зардлыг байгууллага өөрөө хариуцах;” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “хэмжээ” гэснийг “хэмжээний” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “зүйлд” гэснийг “зүйл, үйлчилгээ үзүүлэхэд” гэж, 8.1.7 дахь заалтын “тавихаас” гэснийг “тавих болон” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “буудлын” гэснийг “буудал,” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “газрын” гэснийг “газар, ” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтын “утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад ажлын байрны дотоод орчин;” гэснийг “дотоод орчин, орох хаалганы гадна талаас 50 м-ээс доошгүй зайд;” 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдэг байрлуулна” гэснийг “тамхигүй орчин гэсэн тэмдэг байрлуулж, тусгайлан үнсний сав бэлтгэж байрлуулахыг хориглоно.” гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “2 хувьтай” гэснийг “10 хувьтай” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгт тавих” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтын “янжуур” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “, тамхины ургамал тарих” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “,тамхины ургамал тарих” гэснийг, 9 дүгээр зүйлийн гарчигийн “Утаат” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “утаат” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “,тамхи татахыг хориглосон өрөө” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын “утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад орчин” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2017 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**Гарын үсэг**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/ 15дугаар зүйлийн 15.10.1 дэх заалт:**

“15.10.1. Тамхи үйлдвэрлэх;

**2 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.14 дэх заалтын “импортын” гэсний дараа, “экспортын” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн 15.11.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2017 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ